ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Есөнзүйл сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/12/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Ц.Мөнхзаяа

Утас: 70323108 Цахим хаяг: Munkhzayats@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.Аудитын гэрчилгээ ........ 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 4

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 4**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6**

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 7**

3.Аудитын тайлан ........ 9

**3.1 Ерөнхий зүйл ........ 9**

**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 9**

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10**

**3.4 Материаллаг байдал ........ 10**

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 10**

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 10**

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 11**

**3.8 Аудитын гол асуудал ........ 11**

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 11**

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 11**

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 11**

**3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол ........ 11**

4. Аудитын илрүүлэлт ........ 11

**4.1 Залруулсан алдаа ........ 12**

**Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа зөрчил гараагүй. ........ 12**

**4.2 Зөвлөмж ........ 12**

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 12

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Сандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## 1.Аудитын гэрчилгээ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

82173, Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.21 № 184

танай ______-ны №______-т

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА Т.НАРАНГЭРЭЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнзүйл сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнзүйл сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

015030367

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13299338.00** | **15600938.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 13299338.00 | 15600938.00 |
| **351** | **Түүхий эд материал** | | 2301600.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 2301600.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 13299338.00 | 13299338.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5664000.00 | 5664000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7635338.00 | 7635338.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **247020000.22** | **237349727.00** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 247020000.22 | 237349727.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 241820000.22 | 232099727.00 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 237686679.91 | 237686679.91 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -22393010.88 | -33762576.36 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 14267800.00 | 31730060.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6574699.92 | -22629443.04 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22214270.70 | 25628233.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -15241202.59 | -18893390.11 |
| 39217 | Ном | 11860163.00 | 12340163.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5200000.00 | 5250000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5200000.00 | 5250000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **260319338.22** | **252950665.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **260319338.22** | **252950665.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 260319338.22 | 252950665.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 796797405.00 | 796797405.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 796797405.00 | 796797405.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -537202697.37 | -544571370.59 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -537202697.37 | -537202697.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -7368673.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 724630.59 | 724630.59 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **260319338.22** | **252950665.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **117674928.00** | **142716522.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **259800.00** | **21326222.90** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 259800.00 | 21326222.90 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 259800.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 259800.00 | |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | | 20326222.90 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | | 1000000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **117415128.00** | **121390300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 117415128.00 | 0.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 117415128.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 121390300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 121390300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **134551574.91** | **150085196.12** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **134551574.91** | **150085196.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 129534643.54 | 144424929.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 61578116.00 | 59024679.24 |
| 210101 | Үндсэн цалин | 43424794.00 | 56624679.24 |
| 210102 | Нэмэгдэл | 13324530.00 | |
| 210104 | Урамшуулал | 2628792.00 | 2400000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2200000.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7671854.63 | 7599597.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5217894.31 | 5350810.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 613490.33 | 565662.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 490791.67 | 449169.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 122697.66 | 111030.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1226980.66 | 1122924.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35905750.00 | 38845317.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 265750.00 | 290717.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35640000.00 | 38415600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 139000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3103000.00 | 3323600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 550000.00 | 586900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 896000.00 | 869100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1037000.00 | 1604000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 220000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 400000.00 | 263600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 120000.00 | 116300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 120000.00 | 116300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2769948.00 | 2239450.00 |
| 210604 | Урсгал засвар | 2769948.00 | 2239450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 372000.00 | 568000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 372000.00 | 568000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 831600.00 | 881666.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 831600.00 | 866030.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 15636.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17182374.91 | 31826320.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 300000.00 | 749824.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16882374.91 | 31076496.12 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5016931.37 | 5660266.48 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 150000.00 | 640000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150000.00 | 640000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4866931.37 | 0.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4866931.37 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | 5020266.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 5020266.48 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-16876646.91** | **-7368673.22** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-16876646.91** | **-7368673.22** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **117449200.00** | **121390300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **259800.00** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 259800.00 | 0.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 259800.00 | 0.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 259800.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **117189400.00** | **121390300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 117189400.00 | 0.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 117189400.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 0.00 | 121390300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0.00 | 121390300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **117669200.00** | **120310300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **117669200.00** | **120310300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **112652268.63** | **114650033.52** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 61578116.00 | 59024679.24 |
| 210101 | Үндсэн цалин | 43424794.00 | 56624679.24 |
| 210102 | Нэмэгдэл | 13324530.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 2628792.00 | 2400000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2200000.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7671854.63 | 7599597.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5217894.31 | 5350810.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 613490.33 | 565662.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 490791.67 | 449169.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 122697.66 | 111030.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1226980.66 | 1122924.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35905750.00 | 38803317.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 265750.00 | 290717.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35640000.00 | 38415600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 97000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3103000.00 | 3415200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 550000.00 | 533500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 896000.00 | 869100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1037000.00 | 1804000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 220000.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 400000.00 | 208600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 120000.00 | 116300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 120000.00 | 116300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2769948.00 | 2454450.00 |
| 210604 | Урсгал засвар | 2769948.00 | 2454450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 372000.00 | 568000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 372000.00 | 568000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 831600.00 | 1063666.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 831600.00 | 1048030.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 15636.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 300000.00 | 1604824.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 300000.00 | 1604824.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5016931.37** | **5660266.48** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 150000.00 | 640000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150000.00 | 640000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4866931.37 | 0.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4866931.37 | 0.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 5020266.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 5020266.48 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-220000.00** | **1080000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **0.00** | **1080000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **1080000.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 0.00 | 1080000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 1080000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0.00** | **-1080000.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -220000.00 | 0.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 220000.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 796,797,405.00 | 724,630.59 | -537,202,697.37 | 0.00 | 260,319,338.22 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **796,797,405.00** | **724,630.59** | **-537,202,697.37** | **0.00** | **260,319,338.22** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **796,797,405.00** | **724,630.59** | **-537,202,697.37** | **0.00** | **260,319,338.22** |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **796,797,405.00** | **724,630.59** | **-537,202,697.37** | **0.00** | **260,319,338.22** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **796,797,405.00** | **724,630.59** | **-537,202,697.37** | **0.00** | **260,319,338.22** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -7,368,673.22 | 0.00 | -7,368,673.22 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **796,797,405.00** | **724,630.59** | **-544,571,370.59** | **0.00** | **252,950,665.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 115194400.00 | 112802268.63 | 121390300.00 | 116370033.52 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 115194400.00 | 112802268.63 | 121390300.00 | 116370033.52 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 115094400.00 | 112652268.63 | 120744800.00 | 115730033.52 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 61963700.00 | 61578116.00 | 62432800.00 | 59024679.24 |
| 210101 | Үндсэн цалин | 49243700.00 | 43424794.00 | 60032800.00 | 56624679.24 |
| 210102 | Нэмэгдэл | 12720000.00 | 13324530.00 | | |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 2628792.00 | 2400000.00 | 2400000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8689100.00 | 7671854.63 | 8428500.00 | 7599597.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6114600.00 | 5217894.31 | 5931100.00 | 5350810.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 643600.00 | 613490.33 | 624300.00 | 565662.21 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 514900.00 | 490791.67 | 499500.00 | 449169.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 128700.00 | 122697.66 | 124900.00 | 111030.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1287300.00 | 1226980.66 | 1248700.00 | 1122924.42 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38703000.00 | 35905750.00 | 39500800.00 | 38803317.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 587000.00 | 265750.00 | 684500.00 | 290717.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38016000.00 | 35640000.00 | 38719300.00 | 38415600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100000.00 | 0.00 | 97000.00 | 97000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3390600.00 | 3103000.00 | 3902300.00 | 3895200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 550000.00 | 550000.00 | 533500.00 | 533500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 896000.00 | 896000.00 | 869100.00 | 869100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1509600.00 | 1037000.00 | 1806100.00 | 1804000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 220000.00 | 220000.00 | 485000.00 | 480000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 215000.00 | 400000.00 | 208600.00 | 208600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 120000.00 | 120000.00 | 116300.00 | 116300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 120000.00 | 120000.00 | 116300.00 | 116300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1200000.00 | 2769948.00 | 2455000.00 | 2454450.00 |
| 210604 | Урсгал засвар | 1200000.00 | 2769948.00 | 2455000.00 | 2454450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 160000.00 | 372000.00 | 630500.00 | 568000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 160000.00 | 372000.00 | 630500.00 | 568000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 568000.00 | 831600.00 | 1673300.00 | 1663666.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 568000.00 | 831600.00 | 1649000.00 | 1648030.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 0.00 | 24300.00 | 15636.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 300000.00 | 300000.00 | 1605300.00 | 1604824.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 300000.00 | 300000.00 | 1605300.00 | 1604824.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 100000.00 | 150000.00 | 645500.00 | 640000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 100000.00 | 150000.00 | 645500.00 | 640000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100000.00 | 150000.00 | 645500.00 | 640000.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Есөнзүйл сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн байгууллагын дотоод хяналт, шалгалтын ажил хангалтгүй зохион байгуулсан тул зөвлөмж хүргүүлсэн.

Аудитыг 2022.02.16-наас 2022.02.20–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.07-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.15-ний өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Соёлын тухай хуулийн 25.2.Сум, дүүргийн соёлын төв, соёлын ордон нь тухайн орон нутгийн иргэний соёлын үйл ажиллагаа эрхлэх, бүтээл туурвих, соёлын ололт, үр шимийг хүртэх нөхцөлийг хангах, орон нутгийн байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг сурталчлах, номын сангийн үйлчилгээ хүргэх чиг үүрэгтэй соёлын боловсрол олгох анхан шатны байгууллага бөгөөд соёл, мэдээллийн төв байна" гэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Есөнзүйл сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнзүйл сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 150.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Есөнзүйл сумын Соёлын төвийн 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар төсвийн хөрөнгөөр 1.0 сая төгрөг, 20.3 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгджээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 7.8 сая төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр, 1.0 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр бэлтгэж 6.5 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

Тайлант онд авлага, өглөггүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 5.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан орон нутгийн төсвөөс 121.4 сая төгрөг батлагдаж, 121.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төсвөөс авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар орлого ороогүй байна.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

**3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Есөнзүйл сумын Соёлын төвийн 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 149 мэдээллийг ил тод мэдээлсэн байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар итгэл үзүүлсэн байна.

**3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол**

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1241.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2 албан шаардлага,1 зөвлөмж өгсөн.

**4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа зөрчил гараагүй.

**4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын дотоод хяналт шалгалтын зөвлөлийн ажлыг сайжруулах талаар.

**1.1. Илрүүлэлт:**
Байгууллага нь дотоод хяналт шалгалтын нэгжтэй байхгүй байна.

1.2. Эрсдэл:
Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллахад эрсдэл үүсэж байна..

1.3. Өгсөн зөвлөмж:

Зөвлөмж-1. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж дотоод хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх **1** зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 05 дугаар сарын 01-ний** өдрийн дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Есөнзүйл сумын Соёлын төв | 3 | 1.2 | | | | | 2 | 1.2 | 1 | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Ц.МӨНХЗАЯА

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 20-НИЙ ӨДӨР

## Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт

**Аудитын нэр:** Санхүүгийн тайлангийн аудит **Аудитын код:** ӨВА-2022/12/НА-СТА-ТШЗ

**Байгууллагын нэр:** Есөнзүйл сумын Соёлын төв

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын: Албан тушаал | Шалгагдагч байгууллагын: Овог нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Урсгал зардал | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас багаж хэрэгсэл худалдан авсан, урсгал засварын зардлаас ус цэвэршүүлэгч худалдан авсан | 815.0 | албан шаардлага | Санал байхгүй. | Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190-р тогтоолыг мөрдөж ажиллах | албан шаардлага | Дарга, Нягтлан бодогч | Т.Нарангэрэл Б.Азсүрэн |
| 2 | Урсгал зардал | Төсвийн хөрөнгөөр хувцас худалдан авсан, тэмцээн зохион байгуулсан | 426.3 | албан шаардлага | Санал байхгүй. | Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Монгол улсын засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 " албаны болон ажлын дүрэмт хувцас худалдан авалтыг зохион байгуулахгүй байх ,1.6 Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх | албан шаардлага | Дарга, Нягтлан бодогч | Т.Нарангэрэл Б.Азсүрэн |
| 3 | Дотоод хяналтын тогтолцоо | Байгууллагын дотоод хяналтын нэгж байхгүй | 0 | зөвлөмж | Санал байхгүй. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 19.2-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод аудитын нэгжтэй байж болно | зөвлөмж | Дарга, Нягтлан бодогч | Т.Нарангэрэл Б.Азсүрэн |
| | | | 1241.3 | | | | | | |

Бэлтгэсэн:

АУДИТОР Ц.МӨНХЗАЯА

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

ЕСӨНЗҮЙЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА Т.НАРАНГЭРЭЛ

НЯГТЛАН БОДОГЧ Б.АЗСҮРЭН

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 21 өдөр Дугаар ӨВА-2022/12/НА-СТА-ТШЗ/А1570351/113 Арвайхээр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас багаж хэрэгсэл худалдан авсан, урсгал засварын зардлаас ус цэвэршүүлэгч худалдан авсан зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь "Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190-р тогтоолыг мөрдөж ажиллах заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас багаж хэрэгсэл худалдан авсан, урсгал засварын зардлаас ус цэвэршүүлэгч худалдан авсан зэрэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнзүйл сумын Соёлын төвийн дарга Т.Нарангэрэл, нягтлан бодогч Б.Азсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТОР Ц.МӨНХЗАЯА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 21 өдөр Дугаар ӨВА-2022/12/НА-СТА-Т1113/А15703351/114 Арвайхээр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгөөр хувцас худалдан авч, уралдаан тэмцээн зохион байгуулсан зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь "Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Монгол улсын засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "Албаны болон ажлын дүрэмт хувцас худалдан авалтыг зохион байгуулахгүй байх, 1.6 Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна..

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1.Дээр дурдсан төсвийн хөрөнгөөр ажлын хувцас худалдан авсан, уралдаан тэмцээн зохион байгуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Есөнзүйл сумын Соёлын төвийн дарга Т.Нарангэрэл, нягтлан бодогч Б.Азсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТОР Ц.МӨНХЗАЯА